

# ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

## ЗӨВЛӨМЖ

### ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2017 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ

2017 оны 07 сарын 31

Чойр хот

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Журам батлах тухай” 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн Засаг даргын 2017 оны 07 сарын 05-ны өдөр баталсан “Аймгийн ЗДТГ-ын ажлын хэсэг сумдын Засаг дарга, ЗДТГазар, агентлагуудын 2017 оны хагас жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг үнэлэх ажлын удирдамж”-ийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмжийг боловсрууллаа. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-ийн дарга Х.Буянбаяр, ХШҮДАХ-ийн мэргэжилтэн П.Наранмандах, мэргэжилтэн Б.Өлзийдэлгэр, ХОХБТХ-ийн мэргэжилтэн Н.Батцэцэг, СТСХ-ийн мэргэжилтэн Б.Баярт, НБХ-ийн мэргэжилтэн Ш.Түмэн-өлзий, ТЗУХ-ийн мэргэжилтэн Д.Мөнхзул нар оролцов.

Хяналт-шинжилгээний арга зүйн хувьд бодлогын баримт бичигт туссан тухайн байгууллагын чиг үүргийн асуудлын хэрэгжилт, төсвийн шууд захирагчтай байгуулсан гэрээний хэрэгжилт, байгууллагын ил тод байдалд хамаарах үзүүлэлтүүд, үйл ажиллагааны үр дагавартай танилцаж, холбогдох асуудлуудыг асууж тодруулж, баримт мэдээллүүдийг гаргуулан танилцаж ажилласан. Хяналт-шинжилгээ, үнэлгээний явцад дараах алдаа дутагдал илэрч байна. Үүнд:

1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн хувьд хамааралтай 17 шийдвэрийг хяналтанд бүрэн авч 65,2 хувийн биелэлттэй тайлагнасан. Тайлангийн хэрэгжилтийг бичихдээ зорилт, арга хэмжээнд дүйцүүлж тайлагнаагүй, тоон мэдээллийн зөрүүтэй, хувь хэмжээг буруу тооцсон, утга найруулгын алдаатай байлаа.

2. Аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2017 оны үндсэн чиглэлээс суманд хамааралтай 34 зорилтын 35 арга хэмжээг хяналтанд авч хэрэгжилтийг 41,2 хувийн биелэлттэй тайлагнасан. Тайлан бичихдээ зорилт, арга хэмжээнд дүйцүүлж арга хэмжээ бүрээр тайлагнаагүй. Тухайлбал 3-4 арга хэмжээнд 1 хэрэгжилт бичиж тайлагнасан.

3. МУ-ын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2017 оны үндсэн чиглэлээс 10 зорилтыг хяналтанд авч 41 хувийн биелэлттэй тайлагнасан. Шалгуур үзүүлэлтийг орон нутгийн онцлогт тохируулж оновчтой тодорхойлж түүнд дүйцүүлэн харьцуулан тайлагнаагүй байна. Мөн хэрэгжилтийн хувь хэмжээг буруу тооцсон.

4. Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт, Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг нийтлэг журам”-ын 10-р хавсралтаар Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлтийн хэрэгжилтийг гаргаагүй.

5. Байгууллагын ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийн дагуу хэрэгжилтийг 54,5 хувийн биелэлттэй тайлагнасан. Холбогдох мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбарт бүрэн байршуулаагүй, хүний нөөцийн ил тод байдлыг тайлагнаагүй.

6. Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 105 арга хэмжээг 56,3 хувийн биелэлттэй тайлагнасан. Тайлан бичихдээ зорилт, арга хэмжээнд дүйцүүлж тайлагнаагүй, тоо мэдээллийн зөрүүтэй тайлагнасан.

7. Сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааг үнэлүүлэх ажлын хүрээнд 59 иргэдээс санал, асуулга авсан байна. Иргэдээс санал авсан хэдий ч дүн шинжилгээ хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлоогүй байна.

8. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг бичихдээ зорилт, арга хэмжээнд дүйцүүлж тайлагнаагүй, тоон мэдээллийн зөрүүтэй, хувь хэмжээг буруу тооцсон, утга найруулга, үг үсгийн алдаатай, хэрэгжилтийн хувь хэмжээг буруу тооцсон.

9. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн хүрээнд үйл ажиллагаатай танилцахад дараах мэдээллүүд хугацаа хоцорсон байна.

- ❖ Орон нутгийн хөгжлийн сангийн 6 дугаар сарын төлөвлөгөө, гүйцэтгэл 1 дүгээр сард хугацаа хоцорсон
- ❖ Орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл 1 дүгээр сард хугацаа хоцорсон
- ❖ Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэлийг 2-р сард хугацаа хоцорсон
- ❖ Худалдан авах ажиллагаанд хийсэн аулитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн 2 сард хугацаа хоцорсон

### **Дүгнэлт:**

Сумын Засаг даргын Тамгын газар нь бодлогын баримт бичгийг хяналтанд бүрэн авч төлөвлөлтийг сайн хийсэн байна. Тайлан бичихдээ бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээтэй дүйцүүлж, арга хэмжээ бүрээр нь тайлагнаагүй, тоон мэдээллийн зөрүүтэй, үнэлгээг тооцохдоо ЗГ-ын 2017 оны 89-р тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг хэрэгжүүлж баримтлаагүй байна.

### **Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ:**

1. Тайлангийн чанарт онцгой анхаарч, үг үсэг, утга найруулгын алдаагүй тайлагнах

2. Тайлан бичихдээ тухай бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээнд дүйцүүлж тайлагнах

3. Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг нийтлэг журам”-ыг уншиж судлах, дотоод сургалтаар албан хаагчдад сургалт зохион байгуулах

4. Байгууллагын цахим хуудсанд холбогдох мэдээллийг бүрэн байршуулж ил тод байдлыг хангаж ажиллах

5. Иргэдээс авсан санал асуулгад дүнд шинжилгээ хийж цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох
6. Өргөдөл гомдлыг тайлан, мэдээг улирал бүр сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэрийн хамт аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-т хүргүүлэх
7. Аливаа арга хэмжээг хэрэгжүүлэхэд зарцуулагдсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийг тодорхой бичиж тайлагнах
8. Шилэн дансанд байршуулах мэдээллийг тухай бүр хугацаанд нь оруулж хэвших
9. Худалдан авах ажиллагааны журмыг мөрдөж, цахим хуудсаар тогтмол мэдээллэх
10. Тендерийн баримт баримт бичгийг бүрдүүлж архивт хүлээлгэн өгөхөд бэлтгэх
11. Хөрөнгө оруулалтын ажлуудад мэргэжлийн байгууллагаар төсөв хийлгэж ашиглагч байгууллагаар материалын тооцоо гаргуулсан байх
12. Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 0 хувьтай 11 арга хэмжээ, үнэлэх боломжгүй 22 арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн хангахад анхаарч ажиллах
13. Албан хаагчдын хувийн хэргийн бүрдлийг ТАЗ-ийн 2004 оны 18 дугаар тогтоолын дагуу дараалалд оруулж, бүрдлийг журмын дагуу хангаж, баяжилтыг хийлгэх
14. Байгууллагын орон тоо, цалин санг батлахдаа орон тоо, цалин санг тус бүр хавсралтаар салган гаргаж байх
15. Албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг ТАЗ-ийн 2004 оны 34 дүгээр тогтоолын ажлын байрны тодорхойлолт боловсруулах загвар, аргачлалын дагуу боловсруулж батлуулах. /Байгууллагын бүх албан тушаалтан ажлын байрны тодорхойлолттой болох/
16. Төсвийн шууд захирагчийн үр дүнгийн гэрээг ТАЗ-ийн 2012 оны 134 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтын дагуу гаргах
17. Сум хөгжүүлэх сан, ЖДҮДС-аас зээл авсан иргэдийн эргэн төлөлтийг бүрэн төвлөрүүлэхэд анхаарч ажиллах
18. Аймгийн Засаг даргын 01 дүгээр албан даалгаварын хэрэгжилтийг хангаж ажиллах
19. Өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангаж, гаргасан алдаа дутагдлыг цаашид дахин давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах

## **ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС**

# ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

## ЗӨВЛӨМЖ

### СҮМБЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2017 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ

2017 оны 07 сарын 31

Чойр хот

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Журам батлах тухай” 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн Засаг даргын 2017 оны 07 сарын 05-ны өдөр баталсан “Аймгийн ЗДТГ-ын ажлын хэсэг сумдын Засаг дарга, ЗДТГазар, агентлагуудын 2017 оны хагас жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг үнэлэх ажлын удирдамж”-ийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмжийг боловсрууллаа. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-ийн дарга Х.Буянбаяр, ХШҮДАХ-ийн мэргэжилтэн П.Наранмандах, мэргэжилтэн Б.Өлзийдэлгэр, ХОХБТХ-ийн мэргэжилтэн Н.Батцэцэг, СТСХ-ийн дарга Н.Одонтуяа, НБХ-ийн мэргэжилтэн О.Болор-эрдэнэ, ТЗУХ-ийн мэргэжилтэн Д.Мөнхзул нар оролцов.

Хяналт-шинжилгээний арга зүйн хувьд бодлогын баримт бичигт туссан тухайн байгууллагын чиг үүргийн асуудлын хэрэгжилт, төсвийн шууд захирагчтай байгуулсан гэрээний хэрэгжилт, байгууллагын ил тод байдалд хамаарах үзүүлэлтүүд, үйл ажиллагааны үр дагавартай танилцаж, холбогдох асуудлуудыг асууж тодруулж, баримт мэдээллүүдийг гаргуулан танилцаж ажилласан. Хяналт-шинжилгээ, үнэлгээний явцад дараах алдаанууд гарлаа. Үүнд:

1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн хувьд хамааралтай 17 шийдвэрийг хяналтанд бүрэн авч 63,3 хувийн биелэлттэй тайлагнасан. Тайлангийн хэрэгжилтийг тайлагнахдаа зорилт, арга хэмжээтэй дүйцүүлж тайлагнаагүй, тоон мэдээллийн зөрүүтэй, утга найруулга, үг үсгийн алдаатай, хэрэгжилтийн хувь хэмжээг буруу тооцсон.

2. Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт, Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг нийтлэг журам”-ын 10-р хавсралтаар батлагдсан Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлтийг тайлагнахдаа хэрэгжилтийн хувь, тоо хэмжээ, хүрсэн түвшинг тооцоогүй байсан.

3. Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 114 арга хэмжээний хэрэгжилтийг 40,9 хувийн биелэлттэй тайлагнасан. Хэрэгжилтэд үнэлгээ хийхэд нийт 114 арга хэмжээнээс 29 арга хэмжээг үнэлэх боломжгүй гэж тайлагнагдсан байна.

4. Байгууллагын ил тод байдлыг шалгуур үзүүлэлт бүрийн дагуу 35 хувийн биелэлттэй тайлагнасан. Хэрэгжилтээс харахад байгууллагын цахим хуудас,

мэдээллийн самбарт мэдээлэл бүрэн байршуулаагүй, цахим самбар нь засвартай байсан. Төсвийн гүйцэтгэлийн мэдээллийг шилэн дансны цэсэнд 1-2 хоногоор хоцроож байршуулсан байна.

5. Тамгын газрын дарга хөрөнгө зарцуулах, урамшуулал, нэмэгдэл олгох тушаалдаа холбогдох хуулийн зүйл заалтыг үндэслээгүй, ЗГ-ын тогтоол үндэслэн гаргасан байна. Мөн төрийн үйлчилгээний ажилтинг төрийн захиргааны албан тушаалд томилохдоо анх ажилд орсон тушаалыг хүчингүй болгосон зөрчил гарсан.

6. Төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тоон дээр түр томилгоо хийхдээ ЗГ-ын 2011 оны 62-р тогтоол “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам”-ыг баримтлаагүй, хөдөлмөрийн тухай хууль, хөдөлмөрийн гэрээг үндэслэж томилсон хирнээ хөдөлмөрийн гэрээ, үр дүнгийн гэрээ байгуулаагүй байсан.

7. Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө гаргасан боловч хэрэгжилтийг тооцоогүй хангалтгүй тайлагнасан.

8. Сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааг иргэдээс дүгнүүлэх хүрээнд санал асуулга аваагүй байна.

9. Аймгийн дэд хөтөлбөрүүдээс 3 дэд хөтөлбөрийг хяналтанд авсан ч хэрэгжүүлэх арга хэмжээ дутуу авсан төлөвлөлт, тайлагналт хангалтгүй

10. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийн хүрээнд үйл ажиллагаатай танилцахад дараах мэдээллүүд хугацаа хоцорч тавигдсан байна.

❖ Орон нутгийн хөгжлийн сангийн 6 дугаар сарын төлөвлөгөө, гүйцэтгэлийг хугацаа хоцроосон

❖ Улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг сар бүр оруулсан ч эхний улирал хугацаа хоцроосон.

❖ Засгийн газрын болон орон нутгийн тусгай сангийн орлого, зарлага, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлийг тухай бүр оруулсан ч 3-р сард хугацаа хоцорсон.

❖ Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэлийн мэдээлэл 3-р сард хугацаа хоцорсон.

❖ Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг зэрэг мэдээллийг 1-р сард хугацаа хоцорсон.

**11. ЗДТГ-ын даргын гаргасан тушаалыг хянаж үзэхэд дараах алдаа, зөрчил байлаа. Үүнд:**

❖ Ур чадварын нэмэгдэл олгох тухай Б/02,07,09,12,22,25 дугаар тушаалууд хуулийн холбогдох зүйл заалтыг үндэслээгүй байна.

❖ Урамшуулалт цалин олгох тухай 2017.04.26 Б/26 дугаар тушаалд холбогдох хуулийн үндэслэлгүй ЗГ-ын тогтоол үндэслэн 1 сарын цалингийн урамшуулал олгосон.

❖ 2017.04.05 Б/24, 2017.05.03 Б/29 тоот тушаалаар Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн, Нийгмийн бодлогын мэргэжилтэн нарын албан тушаалд томилгоо хийхдээ 2011 оны 62-р тогтоолыг баримтлаагүй.

❖ 2017.01.24 Б/24 тоот тушаалаар Ж.Ууганцэцэгийг ажилд томилохдоо өмнө томилгоо хийсэн 2013 оны Б/56 тоот тушаалыг хүчингүй болгосон зөрчилтэй байлаа.

#### **Дүгнэлт:**

Хагас жилийн байдлаар гаргасан тайлангийн чанар байдал хангалтгүй тухай бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээтэй дүйцүүлж тайлагнаагүй, тоон

мэдээллийн зөрүүтэй, үнэлгээг буруу тооцсон, утга найруулга, үг үсгийн алдаатай тайлагнасан. Сумын Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн албан хаагч бүрт ЗГ-ын 89-р тогтоолоор сургалт зохион байгуулсан ч мэргэжилтэн бүр өөрсдөө дахин судалж үзээгүйгээс дээрх алдаа дутагдлууд гарч байна. Хийсэн ажил байгаа ч түүнийгээ бүрэн тайлагнаагүй. Сул орон тоон дээр түр томилгоо хийхдээ ЗГ-ын 2011 оны 62-р тогтоол “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгүүлэх журам”-ыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

### **Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ:**

1. Тайлангийн чанар байдалд онцгой анхаарч, үг үсэг, утга найруулгын алдаагүй тайлагнах
2. Тайлан бичихдээ тухай бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээнд дүйцүүлж тайлагнах
3. Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг нийтлэг журам”-ыг уншиж судлах, дотоод сургалтаар албан хаагчдад сургалт зохион байгуулах
4. Байгууллагын цахим хуудсанд холбогдох мэдээллийг бүрэн байршуулах, цахим самбараа ажиллагаатай болгох, мэдээллийн самбарт мэдээллийг бүрэн байршуулж ил тод байдлыг хангаж ажиллах
5. Тушаал гаргахдаа хууль тогтоомжийг уншиж судлан, холбогдох хуулийн зүйл, заалтыг бүрэн авч хуулийн үндэслэлтэй тушаал гаргах
6. Өргөдөл гомдлыг тайлан, мэдээг улирал бүр сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэрийн хамт аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-т хүргүүлэх
7. Сул орон тооны захилгыг аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбарт зөвлөлд хүргүүлж журмын дагуу нөхөн
8. Сум хөгжүүлэх сан, ЖДҮДС-аас зээл авсан иргэдийн эргэн төлөлтийг бүрэн төвлөрүүлэхэд анхаарч ажиллах
9. Аймгийн Засаг дарга болон сумын Засаг даргын хооронд байгуулсан гэрээний хэрэгжилтийн тайланд биелэлтийн товчоо хийх, үнэлэх боломжгүй 29 арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн хангахад анхаарч ажиллах
10. Худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг тухай бүр байгууллагын цахим хуудаст байршуулж хэвших
11. Аудитын дүгнэлтийг мэдээллийн самбар, цахим хуудсанд байршуулах
12. Газрын төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулах
13. Газрын эзэмших гэрээг дүгнэх, газар олгох ажлыг цахим биржээр зохион байгуулах
14. Хөрөнгө оруулалтын ажлын талаарх мэдээллийг цахим хуудсанд тогтмол мэдээлэх
15. Байгууллагын ажил олгогч буюу төсвийн шууд захирагч ажилтанд түүний хүсэлтээр чөлөө олгох хуулийн заалттай тул Хөдөлмөрийн дотоод журамд тусгасан чөлөө олгох асуудлыг Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлд заасны дагуу өөрчлөх;

16. Байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг Хөдөлмөрийн тухай хуулийн 5, 130 дугаар зүйлийн дагуу шинэчлэн батлах;

17. Байгууллагын дунд хугацааны хэтийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах;

18. Байгууллагын төрийн захиргааны албан тушаалын сул орон тоог Төрийн албаны тухай хуулийн дагуу захиалга өгч, сонгон шалгаруулалтын үндсэн дээр ажиллуулах;

19. Хувийн хэргийн бүрдлийг хангаж, баяжилтыг хийж байх;

20. Ажлын байрны тодорхойлолтод заасан мэргэжил, мэргэшлийг тухайн ажлын байрны үйл ажиллагаатай уялдуулан боловсруулах,

21. Албан хаагчдын үр дүнгийн гэрээний баталгаажилт бүрэн хийх;

22. Байгууллагын Ёс зүйн хороог ЗДТГ-ын даргын тушаалаар төрийн жинхэнэ албан хаагчдыг оролцуулан шинэчлэн байгуулах;

23. Ёс зүйн хорооны үйл ажиллагааг жигдрүүлж, Ёс зүйн хорооны бүрэлдэхүүнд хараат бусаар үйл ажиллагаагаа явуулах нөхцлийг бүрдүүлэн ажиллах;

24. Байгууллагын төрийн албан хаагчийн “Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг 2017 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөгүй, байгууллагын дарга батлах, хэрэгжилтийг хангаж ажиллах;

25. Ирүүлж буй мэдээ, тайлангийн бодит үнэн зөв, утга найруулга, хугацаа, чанарыг дээшлүүлэх шаардлагатай;

26. Албан хаагчдыг тогтвор сууршилтай ажиллуулах, чадваржуулж, дадлагажуулах;

27. Аймгийн Засаг даргын 01 дүгээр албан даалгаварын хэрэгжилтийг хангаж ажиллах

28. Өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангаж, гаргасан алдаа дутагдлыг цаашид дахин давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах

## **ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС**

# ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

## ЗӨВЛӨМЖ

### БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2017 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ

2017 оны 07 сарын 31

Чойр хот

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Журам батлах тухай” 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн Засаг даргын 2017 оны 07 сарын 05-ны өдөр баталсан “Аймгийн ЗДТГ-ын ажлын хэсэг сумдын Засаг дарга, ЗДТГазар, агентлагуудын 2017 оны хагас жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг үнэлэх ажлын удирдамж”-ийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмжийг боловсрууллаа. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-ийн дарга Х.Буянбаяр, ХШҮДАХ-ийн мэргэжилтэн П.Наранмандах, мэргэжилтэн Б.Өлзийдэлгэр, ХОХБТХ-ийн дарга Т.Бат-Эрдэнэ, СТСХ-ийн дарга Н.Одонтуяа, НБХ-ийн мэргэжилтэн Ш.Түмэн-өлзий, ХЭЗХ-ийн дарга Д.Магвансүрэн, ТЗУХ-ийн мэргэжилтэн Д.Мөнхзул нар оролцов.

Хяналт-шинжилгээний арга зүйн хувьд бодлогын баримт бичигт туссан тухайн байгууллагын чиг үүргийн асуудлын хэрэгжилт, төсвийн шууд захирагчтай байгуулсан гэрээний хэрэгжилт, байгууллагын ил тод байдалд хамаарах үзүүлэлтүүд, үйл ажиллагааны үр дагавартай танилцаж, холбогдох асуудлуудыг асууж тодруулж, баримт мэдээллүүдийг гаргуулан танилцаж ажилласан. Хяналт-шинжилгээ, үнэлгээний явцад дараах алдаанууд гарлаа. Үүнд:

1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн хувьд хамааралтай 17 шийдвэрийг хяналтанд бүрэн авч тайлагнасан. Тайлангийн хэрэгжилтийг үнэлгээг тооцохдоо зорилт, арга хэмжээнд дүйцүүлж тайлагнаагүй, хувь хэмжээг буруу тооцсон, утга найруулгын алдаатай, биелэлтийн товчоогүй тайлагнасан.

2. Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг нийтлэг журам”-ын 10-р хавсралтаар батлагдсан Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлтийн хэрэгжилтийг гаргаагүй.

3. Байгууллагын ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийн дагуу хэрэгжилтийг 70 хувийн биелэлттэй тайлагнасан. Байгууллагын цахим хуудас ажиллагаагүй учраас холбогдох мэдээллүүдийг цахим хуудсанд байршуулаагүй.

4. Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 113 арга хэмжээг 44,5 хувийн биелэлттэй тайлагнасан. Тайлан бичихдээ зорилт, арга хэмжээнд дүйцүүлж тайлагнаагүй, тоо мэдээллийн зөрүүтэй нийт 113 арга хэмжээнээс тайлан бичээгүй 20



арга хэмжээ, 5 арга хэмжээг 0 хувьтай, хугацаа болоогүй 3 арга хэмжээтэйгээр тайлагнасан.

5. Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөг 15 арга хэмжээтэйгээр төлөвлөж 86,4 хувийн биелэлттэй тайлагнасан.

6. Аймгийн дэд хөтөлбөрөөс 9 дэд хөтөлбөрийг хяналтанд авсан хэдий ч харьяа агентлагуудад мэдэгдэж эзэнжүүлээгүй, хэрэгжилтийн байдлыг гаргаагүй байна.

7. Бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийг бичихдээ зорилт, арга хэмжээнд дүйцүүлж тайлагнаагүй, тоон мэдээллийн зөрүүтэй, хувь хэмжээг буруу тооцсон, утга найруулга, үг үсгийн алдаатай, хэрэгжилтийн хувь хэмжээг буруу тооцсон.

8. Шууд худалдан авч байгаа бараа, ажлын гүйцэтгэгчтэй ямар холбоо харилцаагаар холбогдож сонгосон нь тодорхой бус байна.

9. Ихэвчлэн орон нутгийн бүлэг, компанитай гэрээ байгуулсан нь сайшаалтай боловч тендерийн баримт бичгийн бүрдлийн шаардлага хангалтгүй байна.

### **Дүгнэлт:**

Сумын Засаг даргын Тамгын газар нь нийгмийн бодлогын асуудал, худалдан авах ажиллагаа, дотоод ажил хариуцсан ажлыг 1 мэргэжилтэн хариуцан ажилладаг учраас бодлого төлөвлөлт хангалтгүй, бодлогын баримт бичгүүдийг бүрэн хяналтанд авч эзэнжүүлээгүй учраас тайлан мэдээ хангалтгүй, чанаргүй бичигдэж байна. Энэ байдалд орон нутгийн удирдлага дүн шинжилгээ хийж, батлагдсан төсөвтөө багтаан орон тооны асуудлаа дотроо зохицуулж бодлогын мэргэжилтнүүдийг бүтэн орон тоотойгоор ажиллуулахгүй бол нийгмийн салбарын ажил хоцрогдолтой байна. Нийгмийн салбарын хүрээний бодлого хэрэгжихгүй, бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангалтгүй, салбарын хүрээнд хэрэгжих аймгийн дэд хөтөлбөрийн биелэлт гараагүй мөн аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилт хангалтгүй, 20 арга хэмжээ хэрэгжилтгүй, 5 арга хэмжээ 0 хувьтай байгаад анхаарах шаардлагатай байна.

Төрийн албаны стандартын хувьд өмнө өгсөн зөвлөмжийн дагуу гаргасан алдааг засаж албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж Тамгын газрын даргаар баталгаажуулсан, төрийн үйлчилгээний ажилчдын хөдөлмөрийн гэрээг хуульд нийцүүлэн шинэчилсэн сайн талтай байлаа. Албан хаагчдын хувийн хэргийг журмын дагуу бүрдүүлж, баяжилт хийсэн ч зарим нэгэн алдаа гарсаар байна. Үүнд:

1. Санхүүгийн албаны дарга, нягтлан бодогч, газрын даамал нарын боловсролын дипломын хуулбарыг наториатаар батлуулаагүй.

2. Дотоод ажил хариуцсан мэргэжилтэнд Худалдан авах ажиллагаа, Нийгмийн бодлогын асуудлыг давхар хариуцуулан Хөдөлмөрийн хуулийн 50 дугаар зүйлийг үндэслэн үндсэн цалингийн 20 хувиар тооцон ажил хавсран гүйцэтгэсний нэмэгдэл олгосон нь Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоолын хавсралт “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам”-ын 5.3 дахь заалтыг зөрчиж байна.

3. Мал эмнэлэг үржлийн тасгийн сул орон тоон дээр хөдөлмөрийн гэрээгээр иргэн авч ажиллуулж цалинг Засгийн газрын 2011 оны 62 дугаар тогтоолын хавсралт “Төрийн захиргааны жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх журам”-ын 5.2 дахь заалтыг зөрчин ТҮ-1-1 шатлалаар тооцож үндсэн цалинг бууруулж тогтоосон байна.

### **Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ:**

1. Тайлангийн чанарт онцгой анхаарч, үг үсэг, утга найруулгын алдаагүй тайлагнах
2. Тайлан бичихдээ тухай бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээнд дүйцүүлж тайлагнах, хугацаанд нь ирүүлэх
3. Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг нийтлэг журам”-ыг уншиж судлах, дотоод сургалтаар албан хаагчдад сургалт зохион байгуулах
4. Байгууллагын цахим хуудсыг түргэн хугацаанд ажиллагаатай болгох, холбогдох мэдээллийг бүрэн байршуулж ил тод байдлыг хангаж ажиллах
5. Сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааг иргэдээс үнэлүүлж санал асуулга авч, дүн шинжилгээ хийх
6. Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтэд онцгой анхаарах
7. Өргөдөл гомдлыг тайлан, мэдээг улирал бүр сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэрийн хамт аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-т хүргүүлэх
8. Хувийн хэргийн бүрдлийг хангаж боловсролын дипломын хуулбарыг журмын дагуу наториатаар баталгаажуулах.
9. Гүйцэтгэлийн баримт бичгийн бүрдлийг хангаж ажиллах
10. Худалдан авах ажиллагааны мэргэшүүлэх сургалтанд албан хаагчдаа хамруулах
11. Цахим худалдан авах программыг ашиглах
12. ХАА хариуцсан мэргэжилтнийг мэргэшүүлж, тогтвор сууршилтай ажиллуулах, ХАА-г сумандаа зохион байгуулах
13. Сул орон тоог холбогдох хууль, журмын дагуу нөхөхөд анхаарч ажиллах;
14. Албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах, чадваржуулж, дадлагажуулах;
15. Байгууллагын төрийн албан хаагчийн “Сургалт”, “Ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг 2017 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахад анхаарах;
16. Сум хөгжүүлэх сан, ЖДҮДС-аас зээл авсан иргэдийн эргэн төлөлтийг бүрэн төвлөрүүлэхэд анхаарч ажиллах
17. Төсвийн орлогын төлөвлөгөөг бүрдүүлж ажиллах
18. Аймгийн Засаг даргын 01 дүгээр албан даалгаварын хэрэгжилтийг хангаж ажиллах
19. Өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангаж, гаргасан алдаа дутагдлыг цаашид дахин давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах

**ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН  
ХЭЛТЭС**

# ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

## ЗӨВЛӨМЖ

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН  
2017 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,  
ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ

2017 оны 07 сарын 31

Чойр хот

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Журам батлах тухай” 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн Засаг даргын 2017 оны 07 сарын 05-ны өдөр баталсан “Аймгийн ЗДТГ-ын ажлын хэсэг сумдын Засаг дарга, ЗДТГазар, агентлагуудын 2017 оны хагас жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг үнэлэх ажлын удирдамж”-ийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмжийг боловсрууллаа. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-ийн дарга Х.Буянбаяр, ХШҮДАХ-ийн мэргэжилтэн П.Наранмандах, мэргэжилтэн Б.Өлзийдэлгэр, ХОХБТХ-ийн дарга Т.Бат-Эрдэнэ, СТСХ-ийн дарга Н.Одонтуяа, НБХ-ийн мэргэжилтэн Ш.Түмэн-өлзий, ХЭЗХ-ийн дарга Д.Магвансүрэн нар оролцов.

Хяналт-шинжилгээний арга зүйн хувьд бодлогын баримт бичигт туссан тухайн байгууллагын чиг үүргийн асуудлын хэрэгжилт, төсвийн шууд захирагчтай байгуулсан гэрээний хэрэгжилт, байгууллагын ил тод байдалд хамаарах үзүүлэлтүүд, үйл ажиллагааны үр дагавартай танилцаж, холбогдох асуудлуудыг асууж тодруулж, баримт мэдээллүүдийг гаргуулан танилцаж ажилласан. Хяналт-шинжилгээ, үнэлгээний явцад дараах алдаанууд гарлаа. Үүнд:

1. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн нэгдсэн товчоо гаргаагүйгээс тухайн тайлангийн дундаж үнэлгээ нь харагдахгүй байна.
2. Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөг 9 арга хэмжээтэй төлөвлөж тайлагнасан. Тайлангийн хэрэгжилтийн хувь хэмжээг тооцоогүй.
3. Тайлангийн хэрэгжилтийн хувь хэмжээг ЗГ-ын 89-р тогтоолын хавсралт “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу тооцож үнэлээгүй байсан.

## Дүгнэлт

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар нь 5 орон тоотой үйл ажиллагаагаа явуулж, шинээр батлагдсан гарсан хууль тогтоомжуудыг иргэд, албан байгууллага, аж ахуй нэгжүүд сурталчлан сургалт зохион байгуулан ажиллаж байна. Тус газрын үйл ажиллагаа сайжирсан бодлогын баримт бичгүүдээс холбогдох зорилт арга хэмжээ бүрийг хяналтанд авч төлөвлөлт хийсэн байна. Баримт бичиг эмх цэгцтэй календарчилсан төлөвлөгөөний дагуу ажлаа зохион байгуулан гүйцэтгэлийн тэмдэглэлийг хөтөлсөн.

Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хүрээнд холбогдох мэдээллийг цахим хуудас болон мэдээллийн самбарт бүрэн байршуулсан. Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтийн дагуу биелэлтийг гаргаж 92,5 хувьтай тайлагнасан зэрэг ололттой талууд байна. Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилт 84,1 хувийн биелэлттэй. 2017 оны 06 дугаар сарын 30-ны байдлаар төсөвт 1,708,000 сая төгрөгийн өр үүсгэж аймгийн Засаг даргын 2017 оны “Батлагдсан төсөвтөө багтаан өр авлага үүсгэхгүй анхаарч ажиллах” тухай 01 албан даалгаврын хэрэгжилтийг хангаж ажилаагаагүй байна.

Төрийн албаны стандарт шаардлагыг бүрэн хангаж албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинээр баталж, хувийн хэргийн бүрдлийг журмын дагуу бүрдүүлж, баяжилт тэмдэглэгээг бүрэн хийсэн байна.

### **Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ:**

1. Бодлогын барим бичгүүдийн хэрэгжилтийн нэгдсэн товчоо хийж, дундаж үнэлгээг гаргах
2. Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлтэд үнэлгээ хийж, зөвлөмжийнхөө биелэлтийг хянаж ажиллах
3. ЗГ-ын 2017 оны 89-р тогтоолын хавсралт “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг хэрэгжүүлэх нэг мөр ойлгох зорилгоор албан хаагчдад сургалт зохион байгуулах
4. Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүргийн биелэлтийг хугацаанд нь тогтмол ирүүлж хэвших
5. Аймгийн дэд хөтөлбөрийг хяналтанд авч төлөвлөн, хэрэгжилтийг хангаж ажиллах, тайлагнах
6. Өр авлага үүсгэхгүй батлагдсан төсөвтөө багтаан ажиллах
7. 2018 оны төсөв батлуулахдаа түлш халаалтын зардлаа нэмж батлуулах

## **ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС**

# ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

## ЗӨВЛӨМЖ

### ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН 2017 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ

2017 оны 07 сарын 31

Чойр хот

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Журам батлах тухай” 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн Засаг даргын 2017 оны 07 сарын 05-ны өдөр баталсан “Аймгийн ЗДТГ-ын ажлын хэсэг сумдын Засаг дарга, ЗДТГазар, агентлагуудын 2017 оны хагас жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг үнэлэх ажлын удирдамж”-ийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмжийг боловсрууллаа. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-ийн дарга Х.Буянбаяр, ХШҮДАХ-ийн мэргэжилтэн П.Наранмандах, мэргэжилтэн Б.Өлзийдэлгэр, ХОХБТХ-ийн дарга Т.Бат-Эрдэнэ, СТСХ-ийн дарга Н.Одонтуяа, НБХ-ийн мэргэжилтэн О.Болор-эрдэнэ, ХЭЗХ-ийн дарга Д.Магвансүрэн нар оролцов.

Хяналт-шинжилгээний арга зүйн хувьд бодлогын баримт бичигт туссан тухайн байгууллагын чиг үүргийн асуудлын хэрэгжилт, төсвийн шууд захирагчтай байгуулсан гэрээний хэрэгжилт, байгууллагын ил тод байдалд хамаарах үзүүлэлтүүд, үйл ажиллагааны үр дагавартай танилцаж, холбогдох асуудлуудыг асууж тодруулж, баримт мэдээллүүдийг гаргуулан танилцаж ажилласан. Хяналт-шинжилгээ, үнэлгээний явцад дараах алдаанууд гарлаа. Үүнд:

1. Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийн нэгдсэн товчоо гаргаагүйгээс тухайн тайлангийн дундаж үнэлгээ нь харагдахгүй байна.
2. Тайлангийн хэрэгжилтийн хувь хэмжээг ЗГ-ын 89-р тогтоолын хавсралт “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын үнэлгээний аргачлалын дагуу үнэлээгүй.
3. Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөг 3 арга хэмжээтэй төлөвлөсөн. Тайлангийн хэрэгжилт хангалтгүй, үг үсгийн алдаатай байсан.
4. Аймгийн “Зорилтот бүлэгт чиглэсэн дэд хөтөлбөр”-ийг хяналтанд авч, төлөвлөгөөний маягтын дагуу хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнаагүй.

#### **Дүгнэлт:**

Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар нь 24 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын хавсралт “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ,

үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг хэрэгжүүлж ажиллаагүй, тайлангийн хэрэгжилтийг аргачлалын дагуу тооцоогүй байна.

Төрийн албаны стандартын хэрэгжилтийн хувьд төрийн албан хаагчдын хувийн хэргийн бүрдэл дутуу, Төрийн албан хаагчийн тангаргийн хуудсыг хуулбарласан, ажлын байрны тодорхойлолтыг танилцуулсан, зөвшөөрсөн тэмдэглэл хийсэн зэрэг алдаа дутагдалтай байлаа.

#### **Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ:**

1. Бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн нэгдсэн товчоо хийж, дундаж үнэлгээг гаргах, аргачлалын дагуу хэрэгжилтийн хувь хэмжээ, шалгуур үзүүлэлтийг тооцох

2. Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөөний биелэлтэд үнэлгээ хийж, зөвлөмжийн биелэлтийг хянаж ажиллах

3. ЗГ-ын 2017 оны 89-р тогтоолын хавсралт “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг хэрэгжүүлэх нэг мөр ойлгох зорилгоор албан хаагчдад сургалт зохион байгуулах

4. Аймгийн дэд хөтөлбөрүүд “Төрийн албан хаагчийн харилцаа хандлага, ёс зүйг сайжруулах хөтөлбөр”, “Зорилтот бүлэгт чиглэсэн дэд хөтөлбөр”-ийг хяналтанд авч, тайлагнах, уялдуулж ажиллах

5. Албан тушаалын ажлын байрны тодорхойлолтыг ТАЗ-ийн 2004 оны 34 дүгээр тогтоолд нийцүүлэн боловсруулж, чиг үүргийг хангуулж ажиллах

6. Зарим албан хаагчдын хувийн хэргийн бүрдлийг хангуулж, Төрийн албан хаагчийн тангаргийн хуудсыг эх хувиар нь хувийн хэрэгт хийх

7. Өгсөн зөвлөмжийг арга хэмжээ бүрээр төлөвлөлт хийж, хэрэгжүүлж ажиллах, тайлагнах

8. Политехник коллежтой хамтран ажиллах, хоорондын уялдаа холбоог сайжруулах

9. Түр ажлын байрыг нэмэгдүүлэх зорилтыг хангахад анхаарч ажиллах

10. Аймгийн Засаг даргын 01 дүгээр албан даалгаварын хэрэгжилтийг хангаж ажиллах

#### **ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС**

# ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

## ЗӨВЛӨМЖ

### ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБАНЫ

### 2017 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ

2017 оны 07 сарын 31

Чойр хот

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Журам батлах тухай” 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн Засаг даргын 2017 оны 07 сарын 05-ны өдөр баталсан “Аймгийн ЗДТГ-ын ажлын хэсэг сумдын Засаг дарга, ЗДТГазар, агентлагуудын 2017 оны хагас жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг үнэлэх ажлын удирдамж”-ийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмжийг боловсрууллаа. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-ийн дарга Х.Буянбаяр, ХШҮДАХ-ийн мэргэжилтэн П.Наранмандах, мэргэжилтэн Б.Өлзийдэлгэр, ХОХБТХ-ийн дарга Т.Бат-Эрдэнэ, СТСХ-ийн дарга Н.Одонтуяа, ХЭЗХ-ийн дарга Д.Магвансүрэн нар оролцов.

Хяналт-шинжилгээний арга зүйн хувьд бодлогын баримт бичигт туссан тухайн байгууллагын чиг үүргийн асуудлын хэрэгжилт, төсвийн шууд захирагчтай байгуулсан гэрээний хэрэгжилт, байгууллагын ил тод байдалд хамаарах үзүүлэлтүүд, үйл ажиллагааны үр дагавартай танилцаж, холбогдох асуудлуудыг асууж тодруулж, баримт мэдээллүүдийг гаргуулан танилцаж ажилласан. Хяналт-шинжилгээ, үнэлгээний явцад дараах алдаанууд гарлаа. Үүнд:

1. Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 24 арга хэмжээг 67,8 хувийн биелэлттэй. Гэрээний хэрэгжилтээс 4 арга хэмжээ 0 хувьтай байна.
2. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын хэрэгжилтийн хувь хэмжээг тооцоогүй
3. 2016 оны жилийн эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангаж тайлагнаагүй.
4. Тайлангийн биелэлтийн нэгдсэн товчоо гаргаагүйгээс тухайн тайлангийн дундаж үнэлгээ нь харагдахгүй.
5. Тайлангийн хэрэгжилтийн хувь хэмжээг ЗГ-ын 89-р тогтоолын хавсралт “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын үнэлгээний аргачлалын дагуу үнэлээгүй.

### **Дүгнэлт:**

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын хавсралт “Бодлогын баримт бичгийн

хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг хэрэгжүүлж ажиллаагүй, тайлангийн хэрэгжилтийг аргачлалын дагуу үнэлгээг тооцоогүй байна. Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 4 арга хэмжээ тасарсан байна.

**Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ:**

1. Бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн нэгдсэн товчоо хийж, дундаж үнэлгээг гаргах, аргачлалын дагуу хэрэгжилтийн хувь хэмжээ, шалгуур үзүүлэлтийг тооцох

2. 2016 оны жилийн эцэс, 2017 оны хагас жилийн зөвлөмжийг “Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө” болгон боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж тайлагнах

3. ЗГ-ын 2017 оны 89-р тогтоолын хавсралт “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг хэрэгжүүлэх нэг мөр ойлгох зорилгоор албан хаагчдад дотоод сургалт зохион байгуулах

4. Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний тасарсан 4 арга хэмжээг эрчимжүүлж, арга хэмжээ бүрийг хэрэгжилтийг хангахад анхаарч ажиллах.

5. Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүргийн биелэлтийг хугацаанд нь тогтмол ирүүлж хэвших

6. Аймгийн Засаг даргын 01 дүгээр албан даалгаварын хэрэгжилтийг хангаж ажиллах

**ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН  
ХЭЛТЭС**



# ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

## ЗӨВЛӨМЖ

### ЦАГДААГИЙН ХЭЛТСИЙН 2017 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ

2017 оны 07 сарын 31

Чойр хот

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Журам батлах тухай” 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн Засаг даргын 2017 оны 07 сарын 05-ны өдөр баталсан “Аймгийн ЗДТГ-ын ажлын хэсэг сумдын Засаг дарга, ЗДТГазар, агентлагуудын 2017 оны хагас жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг үнэлэх ажлын удирдамж”-ийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмжийг боловсрууллаа. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-ийн дарга Х.Буянбаяр, ХШҮДАХ-ийн мэргэжилтэн П.Наранмандах, мэргэжилтэн Б.Өлзийдэлгэр, ХОХБТХ-ийн дарга Т.Бат-Эрдэнэ, СТСХ-ийн дарга Н.Одонтуяа, ХЭЗХ-ийн дарга Д.Магвансүрэн нар оролцов.

Хяналт-шинжилгээний арга зүйн хувьд бодлогын баримт бичигт туссан тухайн байгууллагын чиг үүргийн асуудлын хэрэгжилт, төсвийн шууд захирагчтай байгуулсан гэрээний хэрэгжилт, байгууллагын ил тод байдалд хамаарах үзүүлэлтүүд, үйл ажиллагааны үр дагавартай танилцаж, холбогдох асуудлуудыг асууж тодруулж, баримт мэдээллүүдийг гаргуулан танилцаж ажилласан. Хяналт-шинжилгээ, үнэлгээний явцад дараах алдаанууд гарлаа. Үүнд:

1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрээс 4 зүйл заалтыг хяналтанд авч тайлагнасан. Хэрэгжилтийн хувь хэмжээг буруу тооцож үнэлсэн.
2. Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан гэрээг 61,6 хувийн биелэлттэй тайлагнасан. 2 арга хэмжээ 0 хувьтай байна.
3. Аймгийн “ Хуулийн байгууллагуудын үйлчилгээний чанарыг сайжруулах, иргэдэд эрх зүйн мэдлэг олгох дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг 44,4 хувийн биелэлттэй тайлагнасан, хэрэгжилтийн хувь хэмжээг буруу тооцож үнэлсэн.
4. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг 45,1 хувьтай тайлагнасан, хэрэгжилтийн хувь хэмжээг тооцоогүй
5. Аймгийн Засаг даргын захирамжийг хяналтанд авч, хэрэгжилтийг тайлагнаагүй.
6. 2016 оны жилийн эцсийн хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг тайлагнаагүй байна.
7. Тайлангийн хэрэгжилтийн хувь хэмжээг ЗГ-ын 89-р тогтоолын хавсралт “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын үнэлгээний аргачлалын дагуу үнэлээгүй.

### **Дүгнэлт:**

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын хавсралт “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг хэрэгжүүлж ажиллаагүй, тайлангийн хэрэгжилтийг аргачлалын дагуу үнэлгээгүй, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

### **Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ:**

1. Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 0 хувьтай Ногоон гэрэл –цагаан шугам; Оюутан цагдаа эргүүл ажиллуулах 2 арга хэмжээг эрчимжүүлж, хэрэгжилтийг хангаж ажиллах

2. Аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд албан хаагч солилцооны хөтөлбөр, террористтэй тэмцэх сургалтыг зохион байгуулах, хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллах, тайлагнах

3. Тайлангийн хэрэгжилтийн хувь хэмжээ, шалгуур үзүүлэлтийг аргачлалын дагуу зөв тооцож үнэлэх”

4. 2016 оны жилийн эцэс, 2017 оны хагас жилийн зөвлөмжийг “Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө” болгон боловсруулан, хэрэгжилтийг ханган ажиллаж, тайлагнах

5. ЗГ-ын 2017 оны 89-р тогтоолын хавсралт “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг хэрэгжүүлэх нэг мөр ойлгох зорилгоор албан хаагчдад дотоод сургалт зохион байгуулах

6. Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан гэрээний тасарсан 4 арга хэмжээг эрчимжүүлж, арга хэмжээ бүрийг хэрэгжилтийг хангахад анхаарч ажиллах.

7. Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүргийн биелэлтийг хугацаанд нь тогтмол ирүүлж хэвших

8. Аймгийн Засаг даргын 01 дүгээр албан даалгаварын хэрэгжилтийг хангаж ажиллах

## **ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС**

# ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

## ЗӨВЛӨМЖ

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБАНЫ 2017 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ

2017 оны 07 сарын 31

Чойр хот

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Журам батлах тухай” 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн Засаг даргын 2017 оны 07 сарын 05-ны өдөр баталсан “Аймгийн ЗДТГ-ын ажлын хэсэг сумдын Засаг дарга, ЗДТГазар, агентлагуудын 2017 оны хагас жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг үнэлэх ажлын удирдамж”-ийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмжийг боловсрууллаа. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-ийн дарга Х.Буянбаяр, ХШҮДАХ-ийн мэргэжилтэн П.Наранмандах, мэргэжилтэн Б.Өлзийдэлгэр, ХОХБТХ-ийн дарга Т.Бат-Эрдэнэ, СТСХ-ийн дарга Н.Одонтуяа, ХЭЗХ-ийн дарга Д.Магвансүрэн нар оролцов.

Хяналт-шинжилгээний арга зүйн хувьд бодлогын баримт бичигт туссан тухайн байгууллагын чиг үүргийн асуудлын хэрэгжилт, төсвийн шууд захирагчтай байгуулсан гэрээний хэрэгжилт, байгууллагын ил тод байдалд хамаарах үзүүлэлтүүд, үйл ажиллагааны үр дагавартай танилцаж, холбогдох асуудлуудыг асууж тодруулж, баримт мэдээллүүдийг гаргуулан танилцаж ажилласан. Хяналт-шинжилгээ, үнэлгээний явцад дараах алдаанууд гарлаа. Үүнд:

1. Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан гэрээний 49 арга хэмжээг 68,7 хувийн биелэлттэй тайлагнасан. Хэрэгжилт хангалттай.
2. Аймгийн “ Хуулийн байгууллагуудын үйлчилгээний чанарыг сайжруулах, иргэдэд эрх зүйн мэдлэг олгох дэд хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг тайлагнаагүй.
3. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг тайлагнахдаа хэрэгжилтийн хувь хэмжээг тооцоогүй
4. 2016 оны ХШҮ-ний зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж хэрэгжилтийг тайлагнаагүй байна.
5. Тайлангийн хэрэгжилтийн хувь хэмжээг ЗГ-ын 89-р тогтоолын хавсралт “Бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт, Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын үнэлгээний аргачлалын дагуу үнэлээгүй.

### **Дүгнэлт:**

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын хавсралт “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх

нийтлэг журам”-ыг хэрэгжүүлж ажиллаагүй, тайлангийн хэрэгжилтийг аргачлалын дагуу үнэлгээг тооцоогүй, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилаагүй байна.

**Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ:**

1. Аймгийн дэд хөтөлбөрийг төлөвлөгөөний дагуу тайлагнах
2. Бодлогын баримт бичгийн тайлангийн хэрэгжилтийн хувь хэмжээ, шалгуур үзүүлэлтийг аргачлалын дагуу зөв тооцож үнэлэх
3. 2016 оны жилийн эцэс, 2017 оны хагас жилийн зөвлөмжийг “Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө” болгон боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллаж, тайлагнах
4. ЗГ-ын 2017 оны 89-р тогтоолын хавсралт “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг хэрэгжүүлэх зорилгоор албан хаагчдад дотоод сургалт зохион байгуулах
5. Аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний тасарсан 4 арга хэмжээг эрчимжүүлж, арга хэмжээ бүрийн хэрэгжилтийг хангахад анхаарч ажиллах.
6. Аймгийн Засаг даргын 01 дүгээр албан даалгаварын хэрэгжилтийг хангаж ажиллах

**ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН  
ХЭЛТЭС**

# ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

## ЗӨВЛӨМЖ

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН 2017 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ

2017 оны 07 сарын 31

Чойр хот

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Журам батлах тухай” 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн Засаг даргын 2017 оны 07 сарын 05-ны өдөр баталсан “Аймгийн ЗДТГ-ын ажлын хэсэг сумдын Засаг дарга, ЗДТГазар, агентлагуудын 2017 оны хагас жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг үнэлэх ажлын удирдамж”-ийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмжийг боловсрууллаа. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-ийн дарга Х.Буянбаяр, ХШҮДАХ-ийн мэргэжилтэн П.Наранмандах, мэргэжилтэн Б.Өлзийдэлгэр, ХОХБТХ-ийн дарга Т.Бат-Эрдэнэ, СТСХ-ийн дарга Н.Одонтуяа, ХЭЗХ-ийн дарга Д.Магвансүрэн, ТЗУХ-ийн мэргэжилтэн Д.Мөнхзул нар оролцов.

Хяналт-шинжилгээний арга зүйн хувьд бодлогын баримт бичигт туссан тухайн байгууллагын чиг үүргийн асуудлын хэрэгжилт, төсвийн шууд захирагчтай байгуулсан гэрээний хэрэгжилт, байгууллагын ил тод байдалд хамаарах үзүүлэлтүүд, үйл ажиллагааны үр дагавартай танилцаж, холбогдох асуудлуудыг асууж тодруулж, баримт мэдээллүүдийг гаргуулан танилцаж ажилласан. Хяналт-шинжилгээ, үнэлгээний явцад дараах алдаанууд гарлаа. Үүнд:

1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтийн хувь хэмжээг буруу тооцож үнэлсэн.

2. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын тайланг ЗГ-ын 2017 оны 89 дүгээр тогтоолын хавсралт журмын 11 дүгээр хавсралтын дагуу тайлагнасан ч хэрэгжилтийн хувь хэмжээг буруу тооцсон.

3. ЗГ-ын 2017 оны 89 дүгээр тогтоолын хавсралт журмын 10 дугаар хавсралт “Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлтийг тайлагнаагүй.

### **Дүгнэлт:**

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолын хавсралт “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг хэрэгжүүлж ажиллаагүй, тайлангийн хэрэгжилтийг аргачлалын дагуу үнэлгээг тооцоогүй, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шилэн данс, ил тод байдал, санхүүгийн баримт мэдээллүүд бүрэн, хугацаа хоцроогүй оруулсан байна. Мэдээллийг тогтмол хугацаа хоцроолгүй оруулж хэвшсэн нь сайшаалтай байлаа.

#### **Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээ:**

1. Бодлогын баримт бичгийн болон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн хувь хэмжээг аргачлалын дагуу зөв тооцох
2. Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан зорилтын биелэлтийн хэрэгжилтийг хангаж, тайлагнах
3. ЗГ-ын 2017 оны 89-р тогтоолын хавсралт “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг уншиж судалж, хэрэгжүүлж ажиллах
4. Албан тушаалын ажлын байрны тодорхойлолтыг ТАЗ-ийн 2004 оны 34 дүгээр тогтоолоор батлагдсан заавар, аргачлалын дагуу, хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын хэсгээс өгсөн зөвлөмжийн дагуу боловсруулж батлуулах;
5. Албан хаагчдын хувийн хэргийг ТАЗ-ийн 2004 оны 18 дугаар тогтоолын дагуу бүрдлийг дарааллын дагуу хангуулах;
6. Байгууллагын “Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, үр дүнг урамшуулах дэд хөтөлбөр” гэсэн нэршлийг эргэж харж, хууль, журмын дагуу болгох;
7. Төсвийн ерөнхийлөн захирагчаас төсвийн шууд захирагчтай байгуулсан гэрээний хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй 2, 0 хувьтай 4 арга хэмжээг эрчимжүүлж, арга хэмжээ бүрийг хэрэгжилтийг хангахад анхаарч ажиллах
8. 2016 оны жилийн эцэс, 2017 оны хагас жилийн зөвлөмжийг “Гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө” болгон боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллаж тайлагнах
9. Байгууллагын нягтлан бодогч ТҮ-8 цалингийн шатлалаар цалинжих ёстой боловч ТҮ-7 цалинжуулж байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг зөрчиж байгаа тул хууль журмын дагуу шийдвэрлэх
10. Аймгийн Засаг даргын 01 дүгээр албан даалгаварын хэрэгжилтийг хангаж ажиллах

## **ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС**

# ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС

## ЗӨВЛӨМЖ

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ АУДИТЫН АЛБАНЫ 2017 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ  
АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ТУХАЙ

2017 оны 07 сарын 31

Чойр хот

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны “Журам батлах тухай” 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг хэрэгжүүлэх хүрээнд аймгийн Засаг даргын 2017 оны 07 сарын 05-ны өдөр баталсан “Аймгийн ЗДТГ-ын ажлын хэсэг сумдын Засаг дарга, ЗДТГазар, агентлагуудын 2017 оны хагас жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг үнэлэх ажлын удирдамж”-ийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмжийг боловсрууллаа. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ-ийн дарга Х.Буянбаяр, ХШҮДАХ-ийн мэргэжилтэн П.Наранмандах, мэргэжилтэн Б.Өлзийдэлгэр, ХОХБТХ-ийн дарга Т.Бат-Эрдэнэ, СТСХ-ийн мэргэжилтэн У.Занбазар, ТЗУХ-ийн мэргэжилтэн Д.Мөнхзул нар оролцов.

Хяналт-шинжилгээний арга зүйн хувьд бодлогын баримт бичигт туссан тухайн байгууллагын чиг үүргийн асуудлын хэрэгжилт, төсвийн шууд захирагчтай байгуулсан гэрээний хэрэгжилт, байгууллагын ил тод байдалд хамаарах үзүүлэлтүүд, үйл ажиллагааны үр дагавартай танилцаж, холбогдох асуудлуудыг асууж тодруулж, баримт мэдээллүүдийг гаргуулан танилцаж ажилласан. Хяналт-шинжилгээ, үнэлгээний явцад дараах алдаанууд гарлаа. Үүнд:

